


# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЗАГВАРЧЛАЛ

---

Аймгийн өрсөлдөх чадварын тухай


Эдийн засгийн бодлогын өрсөлдөх чадварын судалгааны төвөөс жил бүр 21 аймгийг өрсөлдөх чадвараар нь эрэмбэлж, бодлогын зөвлөмж гаргадаг. 2022 оны байдлаар Өвөрхангай аймаг өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр 21 аймгаас 8-р байрт эрэмбэлэгджээ.

Схем 1. Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ



Үндсэн хүчин зүйл	Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн үр ашиг	Дэд бүтэц
Дэд хүчин зүйлс	Эдийн засаг Эдийн засгийн салбарууд Хүн амын амьжиргааны түвшин Хөдөлмөр эрхлэлт	Аймгийн төсөв Институцийн тогтолцоо Бизнесийн эрх зүй Нийгмийн тогтолцоо	Бизнесийн орчин Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж Санхүү Менежментийн хэвшил	Үндсэн дэд бүтэц Технологийн дэд бүтэц Боловсрол, соёл Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

Схем 2. Өвөрхангай аймгийн өрсөлдөх чадварын үнэлгээний дэлгэрэнгүй (2021 он)




Эх сурвалж: Эдийн засаг бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Аймгийн өрсөлдөх чадварын тухай

Өвөрхангай аймгийн ерөнхий төлөв байдлын үнэлгээгээр засаглалын тогтолцоогоор хамгийн сайн үнэлгээг авсан. Түүнчлэн эдийн засаг, эдийн засгийн салбарууд, аймгийн төсөв зэрэг үзүүлэлтээр сайн үнэлгээтэй байгаа.

Харин үндсэн дэд бүтэц, технологийн дэд бүтэц, эрүүл мэнд хүрээлэн буй орчны үнэлгээний эрэмбээр улсын дундажаас хойгуур байгаа. Иймээс аймгийн өрсөлдөх чадварыг сайжруулах тал дээр бодлого боловсруулан ажиллаж байна.

Схем 3. Өвөрхангай аймгийн өрсөлдөх чадварын төлөв байдлын эрэмбэ (2021 он)




Эх сурвалж: Эдийн засаг бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Аймгийн макро эдийн засгийн өнөөгийн байдал

Монгол улсын эдийн засагт Хангайн бүсийн эзлэх хувийг сүүлийн 23 жилийн байдлаар авч үзвэл 2010 онд хамгийн өндөр буюу 15.7 хувь байжээ. Гэхдээ Өвөрхангай аймгийн Хангайн бүсийн эдийн засагт эзлэх хувь энэ үед хамгийн бага түвшинд байсан.

Өвөрхангай аймгийн эдийн засаг 2010 оноос Хангайн бүсийн эдийн засагт эзлэх хувь аажим нэмэгдсээр 2016 онд хамгийн их хувь буюу 14.2 хувьд хүрсэн. Цар тахлын дараа үеэс энэ үзүүлэлт буурч 9.9 хувь хүрсэн ч 2022 онд 0.6 нэгж хувиар нэмэгдсэн.

Схем 4. МУ-ын эдийн засгийн өсөлт, Хангайн бүс, Өвөрхангай аймгийн ДНБ-ий эзлэх хувь




Эх сурвалж: ҮСХ-ний цахим мэдээллийн хуудас

Эдийн засгийн чадавх

Аймгийн хөгжлийн одоогийн түвшинг эдийн засгийн чадавхаар нь улсын болон бүсийн хэмжээнд дараах байдлаар харьцуулвал.

Улаанбаатар, Орхон, Өмнөговь зэрэг уул уурхай, хот суурин газрын аж ахуйн бүтэц давамгайлсан аймгуудыг эс тооцвол ДНБ-ий хэмжээгээр тус аймаг улсын дундажаас дээгүүр түвшинд байгаа.

Схем 5. Дотоодын Нийт Бүтээгдэхүүн, аймгаар, 2022, 2021 он



Эх сурвалж: ҮСХ-ний цахим мэдээллийн хуудас


Дотоодын нийт бүтээгдэхүүн

Аймгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн өсөлтийн хурд улсын хэмжээнд болон хангайн бүсийн хэмжээнд нэлээд өндөр байна.

Оны үнээр тооцсон аймгийн ДНБ 2015 онтой харьцуулахад 2022 онд ойролцоогоор 80 гаруй хувиар нэмэгдсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн үзүүлэлттэй буюу 756 тэрбум төгрөг болсон.

Аймгийн эдийн засгийн салбарыг 2022 оны байдлаар авч үзвэл ДНБ-хээ хагасыг буюу 378 тэрбум төгрөгийг ХАА-н салбараас, 36 хувь буюу 269 тэрбум төгрөгийг үйлчилгээний салбараас, үлдсэн 14 хувь буюу 109 тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн салбараар бий болгожээ.

Схем.6 2022 оны Өвөрхангай аймгийн ДНБ /эдийн засгийн салбаруудаар/




Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас, Судлаачийн тооцоолол

## Аймгуудын эдийн засгийн бүтэц, салбараар

Тус аймгийн эдийн засгийн бүтцийг бусад аймгуудтай харьцуулан харвал үйлдвэрлэл, уул уурхай болон үйлчилгээ хөгжсөн бусад аймгуудтай харьцуулахад бага ч ХАА-н салбар голлох хувийг бүрдүүлдэг аймгуудтай ижил түвшинд байна.

Зураг 7. Аймгуудын эдийн засгийн бүтэц, салбараар, 2013-2021 оны дундаж утга



Одоогийн нөхцөлд байдалд уламжлалт ХАА-г орчин үеийн дэвшилтэт технологитой нийцүүлж, гарцыг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний борлуулалтын эргэцийг сайжруулах, малчдын хоршин ажиллах боломж, бүтээгдэхүүнийг нь зах зээлд саадгүй оруулах дэд бүтцийг бий болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

## Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

Эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч гол хөшүүргийн нэг болох аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин цар тахлын үед буурсан 2021 оноос сэргэж сүүлийн оны эцсийн байдлаар 67 хувь болсон байна. Цаашид ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд аймаг өөрийн нөөц бололцоог илүү дайчлах, ингэхдээ гаднын болон дотоодын томоохон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллах нь чухал юм.

Зураг 8. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, 2010-2022 он




Цаашид бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хурдацтай өсөх тохиолдолд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь багасаж худалдаа, зочид буудал, аж үйлдвэр, аялал жуулчлал, тээвэр логистикийн салбар эзлэх хувь нэмэгдэх болно. Аймгийн хувьд хэт нэг салбараас хамаарах хамаарлыг бууруулах замаар эдийн засгийг төрөлжүүлнэ.

**Төсөв, санхүүгийн нөхцөл байдлын шинжилгээ**

Орлогын бие даасан байдал нь төсвийн төвлөрлийг сааруулж, тухайн аймаг төрөл бүрийн эх үүсвэр, санхүүжилтээр орлого төвлөрүүлэх, хувь хэмжээг тодорхойлох эрхтэй байх нь орлого олох боломжтойг илтгэнэ.

Орлогын биедаасан байдал=Орон нутгийн өөрийн орлого /Орон нутгийн нийт орлого

Схем 9. Өвөрхангай аймгийн орлогын бие даасан байдлын үнэлгээ



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Орон нутгийн орлогын бие даасан шинжилгээнээс үзэхэд тухайн аймгийн орлогын бие даасан байдал тасралтгүй нэмэгдсэн үр дүн гарсан. 2022 оны байдлаар тус харьцаа 0.527 буюу орон нутгийн нийт орлогын 52.7 хувийг орон нутаг өөрийн орлогоосоо бүрдүүлсэн гэдгийг илтгэж байна. 2013 онтой харьцуулахад орон нутгийн орлогын бие даасан байдал 2022 онд 4.2 дахин өссөн нь аймгийн орлогын менежмент сайжирсныг харуулж байна.

**Татварын орлогын бие даасан байдал**

Татварын орлогын бие даасан нь татварын шинэ төрөл гарах, татварын хувь хэмжээг тогтоох, татварын суурь тодорхойлох, хувь хүн болон аж ахуй нэгжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх зэрэг төвлөрсөн төсвөөс хамаарах байдлыг харуулдаг үзүүлэлт юм.

Татварын орлогын татварын биедаасан байдал=Орон нутгийн татварын орлого/ Орон нутгийн нийт орлого

Схем 10. Өвөрхангай аймгийн татварын орлогын бие даасан байдлын үнэлгээ



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Аймгийн хувьд татварын орлогын бие даасан байдал Ковид-19 цар тахлын жилд буурснаас бусдаар тасралтгүй өссөн үр дүн гарчээ. Татварын орлогын бие даасан байдлын үнэлгээгээр 2022 онд аймгийн нийт орлогын 37.7 хувийг татварын орлогоор бүрдүүлсэн байгаа нь өмнөх 2021 онтой харьцуулахад 0.2 нэгж буюу 20 нэгж хувиар нэмэгдсэн.

Татварын бус орлогын биедаасан байдал

Орон нутгийн татварын бус орлого нэмэгдэхийн хэрээр орон нутгийн санхүүгийн бие даасан байдал нэмэгддэг. Монгол улсын хувьд орон нутгийн татварын бус орлогод нийтлэг татварын бус орлого буюу торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн үндсэн болон туслах орлого, түрээсийн орлогыг тооцож байна.

Татварын бус орлогын биедаасан байдал = Орон нутгийн татварын орлого / Орон нутгийн нийт орлого

Схем 11. Өвөрхангай аймгийн татварын бус орлогын бие даасан байдлын үнэлгээ



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Аймгийн хувьд татварын бус орлого 2019 онд огцом буурсан боловч үүнээс хойш жил бүр тасралтгүй өсөж байна.

Орон нутгийн санхүүгийн чадавх

Орон нутгийн санхүүгийн чадавх өөрийгөө санхүүжүүлэх чадвараас бүрэн шалтгаалдаг учраас нөгөө талдаа санхүүгийн хүндрэлийн асуудал болдог. Орон нутгийн санхүүгийн чадавхын асуудал орон нутгийн хүн амын хэрэгцээ, шаардлагыг хангах орлого бүрдүүлэх бизнесийн боломж, нөөцтэй шууд хамааралтай болохоос гадна нөөцийг бүрдүүлэх, хуваарилахтай холбоотой орон нутгийн үүрэг, хариуцлага, удирдлагаас шалтгаална.

Орон нутгийн санхүүгийн чадавх = Орон нутгийн нийт орлого / Орон нутгийн нийт зардал

Схем 12. Өвөрхангай аймгийн орон нутгийн санхүүгийн чадавхын үнэлгээ



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол


Орон нутгийн санхүүгийн чадавхын үнэлгээгээр сүүлийн 23 жилийн 22 жилд энэ харьцаа 1-ээс их утга 1 төгрөгийн зарцуулалтаас түүнийг нөхөхүйц хэмжээний орлого сайн олсныг илтгэж байна. 2022 оны байдлаар тус харьцаа 1.144 буюу 1 төгрөгийн зарцуулалтаас 1.144 төгрөгийн орлого олсныг харуулж байгаа гэсэн эерэг үр дүн гарч байна.

Орон нутгийн хөрөнгийн зардлын харьцаа

Орон нутгийн хөрөнгийн зардлын харьцаа нь орон нутгийн хөгжлийг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, бусад хөрөнгө худалдан авалтын зардлыг харуулдаг.

Орон нутгийн капиталын зардлын харьцаа = Орон нутгийн хөрөнгийн зардал / Орон нутгийн нийт зардал

Схем.13 Өвөрхангай аймгийн капитал буюу хөрөнгийн зардлын харьцаа




Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Орон нутгийн хөрөнгийн зардлын харьцаа 2022 онд 0.198 буюу нийт зардлын 20 гаруй хувийг хөрөнгийн зардал эзэлж буйг илтгэж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн нөхцөл байдал

Аймгийн санхүүгийн зах зээлийн боломж, эдийн засгийн өндөр өсөлт Өвөрхангай аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалттай нягт уялдаа, холбоо хамааралтай юм. Нийт хөрөнгө оруулалт 2016 оноос хойш эрчимтэй нэмэгдэж 2019 онд 58 тэрбумд хүрсэн нь аймгийн ДНБ-ий 40 орчим хувьтай тэнцэж байна. Гэвч цар тахлын үеэр аймаг дахь хөрөнгө оруулалтууд буурсан сөрөг нөлөө байгаа ч 2022 оноос хөрөнгө оруулалт эргэн сэргэж 42 тэрбумд хүрсэн. Цаашид хөрөнгө оруулалт жил бүр нэмэгдэх дүр зураг ажиглагдаж байгаа ч үр ашгийн сайжруулах, тухайлбал үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, дэд бүтцийг сайжруулах болон ирээдүйд эргээд эдийн засгийн хувьд ашиг өгөх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх боломжтой төслүүдэд хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтүүдээ чиглүүлж үе шаттай хэрэгжүүлэх нь чухал байна.

Схем.14. Өвөрхангай аймгийн хөрөнгө оруулалт, сая төгрөгөөр, 2011-2022 он




Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас

Хөрөнгө оруулалтын хэмжээ өндөр байх нь аймгийн эдийн засгийн өсөлтийг хангах гол эх үүсвэр болдог гэдэг утгаар цаашид аймгийн зүгээс энэ тал дээр анхаарах ёстой.

Хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэр нь төсөв байхаас гадна иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламж байдаг. Тиймээс хадгаламжийн хэмжээ хэдий чинээ их байна төдий чиний хөрөнгө оруулалт нэмэгдэх боломж бүрддэг.



Схем 15. Хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/, 2019-2022 он




Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас

### Хадгаламжийн хэмжээ

Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар хадгаламж 163 тэрбумд хүрсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар буурсан үзүүлэлт гарав. Хангайн бүсэд 3-р байранд эрэмбэлэгдэж байгаа ба эхний байранд буй Орхон аймгаас 2.3 дахин, 2-р байранд эрэмбэлэгдэж буй Хөвсгөл аймгаас 1.1 дахин бага байна. Хадгаламжийн хэмжээгээр уул уурхай, аж үйлдвэрт түшиглэсэн аймгийг эс тооцвол Хангайн бүсийн аймгууд дундаа тэргүүлэх хэмжээнд хүрч, Баянхонгор, Булган, Архангай аймгаас дээгүүр байна. Энэ нь аймгийн хэмжээнд санхүүгийн үзүүлэлтүүд сайн байж, иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаагийн илэрхийлэл бөгөөд цаашид аймаг өөрийн зах зээлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэхээр харагдаж байна. Санхүүгийн үзүүлэлтүүдийн хөгжлийг илэрхийлдэг чухал үзүүлэлт нь зээлийн үлдэгдлийн хэмжээ байдаг. Аймгийн хэмжээнд иргэд, аж ахуй нэгжүүд хэр их хэмжээний зээлийн эх үүсвэрээр хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжиж байгааг харах шаардлагатай.

Схем 16. Аймгийн иргэдийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас


### Аймгийн иргэдийн зээлийн үлдэгдэл

Аймгийн хэмжээгээр 2019 онд зээлийн үлдэгдэл 234.1 тэрбум төгрөг байсан бол хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн үр дүнд сүүлийн 2 жилд Орхон аймгаас бусад аймагтай харьцуулахад зээлийн хэмжээ нэлээд өсөлттэй гарч, 2021 онд 36 хувь, 2022 онд 4 хувиар тус тус өсөж 291.8 тэрбумд хүрээд байна.

Зээл олголтод чанаргүй зээлийн эзлэх хувь өндөр байх нь эргээд эдийн засагтаа ихээхэн сөрөг нөлөөтэй байдаг.

Өвөрхангай аймгийн зах зээлийн багтаамж, цаашдын өсөлтөд санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин өндөр ач холбогдолтой бөгөөд бүсийн хэмжээнд хамгийн бага аймгуудын тоонд орж байна. Тухайлбал, цар тахлын үед чанаргүй зээл 35 хувиар нэмэгдсэн ч 2022 оны жилийн эцсийн байдлаар 3 хувиар буурч 2.9 тэрбумд хүрчээ. Хангайн бүсийн хувьд чанаргүй зээлийн өсөлт хамгийн өндөр аймгаар Баянхонгор аймаг тодорсон ба тайлант онд 117 хувиар өсжээ.

Схем 17. Чанаргүй зээлийн хэмжээ, сая төгрөгөөр, 2018-2021 он



Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас

### Чанаргүй зээлийн хэмжээ


Монгол улсын хэмжээнд санхүүгийн зах зээл зөвхөн мөнгөний зах зээл буюу хадгаламж, зээлийн талаас түлхүү хөгжсөн. Цар тахлын дараа хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хурдац дэлхийн бусад улсуудтай харьцуулахад өндөр өсөлтийг үзүүлсэн юм. Тиймээс орон нутгийн ААН, иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хөрөнгийн зах зээлийг Өвөрхангай аймагт хөгжүүлэх чиглэлд ажиллах, орон нутгийн бонд гаргах, урт хугацаат капиталууд болох өрийн болон өмчийн санхүүжилтийн орчны эрх зүйн орчныг аймагтаа бий болгох зорин ажиллаж байна.

### Хүн ам, хөдөлмөрийн нөөц, ажилгүйдэл

Өвөрхангай аймаг нь хүн амын тоогоороо улсдаа Хөвсгөл аймгийн дараа 2 дугаарт орж байна. Монгол Улсын нийт хүн амын 3.4 хувь, Хангайн бүсийн 20 хувь нь Өвөрхангай аймагт амьдарч байна. 2022 оны байдлаар суурин хүн амын тоо 115'347 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.33 хувиар буурсан нь хүн амын өсөлт улсын дунджаас 1.81 нэгж хувиар бага, Хангайн бүсийн дунджаас 0.27 нэгж хувиар тус тус бага байна.

Хүн ам зүйн ачааллыг авч үзвэл хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох байдлаар авч үзвэл 57 байна. Үүнээс насанд хүрээгүй буй хүүхдийн хувьд тооцсон хүн ам зүйн ачаалал 49.8 байгаа бол бол хөгшдийн хувьд 7.2 байна. Өвөрхангай аймгийн хүн амын өсөлт 2010-2022 оны хооронд жилд дунджаар 0.9 хувь байсан бол сүүлийн 23 жилийн 7 жилд нь хүн амын өсөлт сөрөг утгатай гарсан. Аймгийн хувьд 2014 онд хүн ам хамгийн ихээр нэмэгдсэн бөгөөд тухайн жилдээ хүн амын дундаж өсөлт 12 хувьд хүрсэн.

Схем 18. Өвөрхангай аймгийн хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь /2010-2022 он/




Эх сурвалж: ҮСХ цахим мэдээллийн хуудас

Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор

2022 оны байдлаар Өвөрхангай аймагт амьд төрөлтийн тоо 1987 байгаа нь хангайн бүсийн нийт амьд төрөлтийн 19.3 хувь болж байна. Аймгийн 1000 хүнд ногдох төрөлт 20.3, 1000 хүнд ногдох нас баралт 6.2 байгаа бөгөөд эндээс хүн амын цэвэрт өсөлтийг тооцож үзвэл 14.1 гарч байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүн амын цэвэр өсөлт 0.3 нэгжээр буурсан. Сүүлийн 23 жилийн хугацаан цуваанаас харахад хүн амын цэвэр өсөлт 2014 онд хамгийн өндөр буюу 23.2 хүрсэн болно.

Схем 19. Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, /2000-2022 он/






# ОРОН ЗАЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЧЛАЛ, ТООЦОО ШИНЖИЛГЭЭ



Эдийн засгийн загварчлал боловсруулах аргагүйн шалгуур үзүүлэлт:



Зураг. 1 Өвөрхангай аймагт мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэх тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад Арвайхээр, Тарагт, Хайрхандулаан, Нарийнтээл, Баянгол, Баян-Өндөр, Бүрд, Есөнзүйл, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан, Өлзийт сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.




Зураг. 2 Өвөрхангай аймагт арьс, ширний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт арьс ширэн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд арьс, ширний үйлдвэр хөгжүүлэхэд Арвайхээр, Хархорин, Баянгол, Уянга, Богд, Баян-Өндөр сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.




Зураг. 3 Өвөрхангай аймагт ноос, ноосны үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт ноос, ноосон бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд ноос, ноосны үйлдвэрлэл хөгжүүлэхэд Арвайхээр, Баянгол, Гучин-Ус, Баян-Өндөр сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.



Зураг. 4 Өвөрхангай аймагт ноолуур, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт ноолуур, ноолууран бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд ноолуур, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд Арвайхээр, Хайрхандулаан, Нарийнтээл, Баянгол, Баян-Өндөр сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.






Зураг. 5 Өвөрхангай аймагт сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр хөгжүүлэхэд Хужирт, Хархорин, Есөнзүйл, Тарагт сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.




Зураг. 6 Өвөрхангай аймагт үр тариа боловсруулах үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт үр тариа боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд үр тариа боловсруулах үйлдвэр хөгжүүлэхэд Бат-Өлзий, Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Уянга, Зүүнбаян-Улаан сумд нэн тохиромжтой үнэлгээтэй байна.



Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.


Өвөрхангай аймагт хөдөө аж ахуйн аль нэг чиглэлээр хөгжүүлэхэд байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон кластер байдлаар боловсруулах үйлдвэр байгуулахад тохиромжтой бүсчлэлийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг төрөлжүүлэхэд дараах чиглэлээр сумд кластер, хоршоо маягаар хөгжихөд тохиромжтой байна. Үүнд:

- Мах-сүүний үхэр, мах-өөх-ширүүн хонины аж ахуйн чиглэлээр кластер хэлбэрээр хоршин хөгжүүлэхэд Зүүнбаян-Улаан, Уянга, Бат-Өлзий сумд тохиромжтой;
- Үр тарианы хавсарга салбар бүхий мах-сүүний үхэр, нарийвтар ба ширүүвтэр ноост хонины аж ахуйн чиглэлээр кластер хэлбэрээр хоршин хөгжүүлэхэд Хужирт, Хархорин, Бүрд, Есөнзүйл, Өлзийт сумд тохиромжтой;
- Мах-Өөх, ширүүн ба ширүүвтэр ноост хонь зонхилсон аж ахуйн чиглэлээр кластер хэлбэрээр хоршин хөгжүүлэхэд Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт, Баянгол, Сант, Арвайхээр, Баян-Өндөр сумд тохиромжтой;
- Мах-Өөх-ширүүвтэр ноост хонь, ямаа, тэмээний аж ахуйн чиглэлээр кластер хэлбэрээр төрөлжин хөгжүүлэхэд Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Төгрөг, Богд сумд нэн тохиромжтой байна.

Зураг.7 Өвөрхангай аймагт хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлжүүлэн хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг






Зураг. 8 Өвөрхангай аймагт мод, модон эдлэлийн үйлдвэр хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг

Тайлал: Дээрх зураглалд өнгө тодрох тусам хөгжүүлэх нөөц боломж илүү байгааг харуулна.

Өвөрхангай аймагт мод, модон эдлэлийн боловсруулах үйлдвэр байгуулахад байгаль орчин, эдийн засаг, нийгмийн шалгуур үзүүлэлтээр үнэлэн тодорхойлсон хөгжүүлэхэд тохиромжтой нөөц потенциалтой бүс нутгийг харуулж буй зураглал.

Өвөрхангай аймгийн хэмжээнд мод, модон эдлэлийн боловсруулах үйлдвэр хөгжүүлэхэд Бат-Өлзий, Уянга, Зүүнбаян-Улаан, Тарагт сумд тохиромжтой үнэлгээг үзүүлж байна.




Зураг. 9 Эртний хотын туйр, хэрэм балгас

Өвөрхангай аймгийн газар нутгаас олдсон эртний хотын туйр, хэрэм балгасын нөөцийн зураглал, түүний нягтшилийг харуулж байна. Үүнд:

- Эртний хотын туйр, хэрэм балгас-3
- XIII зууны үеийн хотын туйр, хэрэм балгас-3
- Уйгурын үеийн хотын туйр, хэрэм балгас-5
- Үйлдвэржиж буй газруудын үлдэгдэл, туйр-2 байгааг харуулж байна.

## Өвөрхангай аймгийн төлөвлөж буй авто замын зураглал



### Хэрэгжүүлэх төсөл

Стратегийн хөгжлийн төв хотуудыг хөрш орнуудын хотуудтай транзит дэд бүтцээр холбох бодлого


Бага-Илэнх – Арвайхээр – Шивээхүрэн босоо коридорт:

- Шивээхүрэн боомт – Арвайхээр/ӨВ/ чиглэлийн 451км,
- Арвайхээр/ӨВ/ – Шинэ Хархорум чиглэлийн 170км
- Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн замаас – Есөнзүйл сум чиглэлийн 15 км
- Улаанбаатар – Арвайхээр чиглэлийн замаас – Гучин-Ус чиглэлийн 95 км

- |  |                                     |  |                        |
|--|-------------------------------------|--|------------------------|
|  | Одоо байгаа авто зам                |  | Одоо байгаа төмөр зам  |
|  | Босоо коридор                       |  | Төлөвлөж буй төмөр зам |
|  | Төлөвлөж буй авто зам               |  |                        |
|  | Олон улсын тээвэр логистикийн төв   |  |                        |
|  | Бүсийн тээвэр логистикийн төв       |  |                        |
|  | Орон нутгийн тээвэр логистикийн төв |  |                        |

Зураг. 19 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй авто замын зураглал


## Өвөрхангай аймагт төлөвлөж буй тээвэр, логистикийн төсөл



Зураг. 20 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй тээвэр, логистикийн зураглал



# Өвөрхангай аймагт төлөвлөж буй аялал жуулчлалын төсөл




Зураг. 21 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй аялал жуулчлалын зураглал

## Өвөрхангай аймагт төлөвлөж харилцаа холбооны төсөл

### Хэрэгжүүлэх төсөл


Арвайхээр хотод интернэтийн харилцан холболтын төв (IXP) байгуулна.

- Үүрэн холбооны шугам
- Одоо байгаа авто зам
- Босоо коридор
- Төлөвлөж буй авто зам
- 📶 Тоон нэвтрүүлгийн станц
- Үүрэн холбооны төв
- Интернет холболтын төв




Зураг. 23 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй харилцаа холбооны зураглал

## Өвөрхангай аймагт төлөвлөж буй хөдөө аж ахуйн хөгжлийн байршлын төсөл



Зураг. 24 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй хөдөө аж ахуйн хөгжлийн байршлын зураглал

# Өвөрхангай аймагт төлөвлөж буй хөнгөн үйлдвэрлэлийн байршлын төсөл



Зураг. 25 Өвөрхангай аймгийн төлөвлөж буй хөнгөн үйлдвэрлэлийн байршлын зураглал